



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН ТУШААЛ

2014 оны 12 сарын 05 өдөр


Дугаар 430

Улаанбаатар хот

Г Осол гэмтлийн тандалт, мэдээллийн
алба байгуулах тухай

Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2, Эрүүл мэндийн тухай хуулийн 8.1.14, Засгийн газрын 2009 оны 279 дугаар тогтоолоор батлагдсан “Осол гэмтэл, хүчирхийллээс сэргийлэх үндэсний хөтөлбөр”-ийн 4.2.1.1 дах заалтыг хэрэгжүүлэх зорилгоор ТУШААХ нь:

1. “Осол гэмтлийн тандалт, мэдээллийн алба”-ны ажиллах журмыг хавсралтаар баталсугай.
2. Гэмтэл согог судлалын үндэсний төвд “Осол гэмтлийн тандалт мэдээллийн алба” байгуулах орон тоог батлан санхүүжүүлэхийг Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар (Я.Буянжаргал), осол гэмтлийн өвчлөл, нас баралтын тандалтын мэдээллийг цуглуулах, дамжуулах, нэгтгэх, эргэн мэдээлэх, дүн шинжилгээ хийх ажлыг үндэсний түвшинд зохион байгуулж, эрт сээрэмжлүүлэх, хариу арга хэмжээ авах, мэргэжил арга зүйгээр хангаж ажиллахыг Гэмтэл согог судлалын үндэсний төв (З.Мэндсайхан)-д даалгасугай.
3. Уг тушаалын хэрэгжилтийг хангаж ажиллахыг аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газар, төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төвийн дарга, захирал нарт даалгасугай.
4. Энэ тушаал гарсантай холбоотойгоор Эрүүл мэндийн сайдын 2011 оны 434 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтын Осол гэмтлийн тохиолдлыг бүртгэх мэдээлэх тогтолцооны удирдлага, зохион байгуулалт хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.



022506

Эрүүл мэндийн сайдын 2014 оны 12.
сарын 15. өдрийн 130 дугаар
тушаалын хавсралт

“Осол гэмтлийн тандалт, мэдээллийн алба”-ны ажиллах журам

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1 Гэмтэл согог судлалын үндэсний төвийн Тандалт, мэдээллийн үндэсний алба нь үндэсний түвшинд осол гэмтлийн өвчлөл, нас барагтай холбоотой мэдээ, мэдээллийг тогтмол цуглуулах, нэгтгэх, дүн шинжилгээ хийх, эргэн мэдээлэх, хариу арга хэмжээ авах, нотолгоонд тулгуурласан шийдвэр гаргахад дэмжлэг үзүүлэх үйл ажиллагааг хариуцан ажиллана.
- 1.2 Гэмтэл Согог Судлалын Үндэсний Төвд “Осол гэмтлийн тандалт мэдээллийн алба” ажиллах ба албаны дарга, статистик их эмч, тархвар судлаач эмч, нийгмийн эрүүл мэндийн мэргэжилтэн, статистик бага эмч, мэдээллийн технологич зэрэг нийт 8-10 хүний бүрэлдэхүүнтэй байна.
- 1.3 Аймгийн эрүүл мэндийн газар, дүүргийн эрүүл мэндийн нэгдэл, нэгдсэн эмнэлэг нь нийгмийн эрүүл мэндийн асуудал хариуцсан хэлтсийн даргаар ахлуулсан халдварт бус өвчний тархвар судлаач, осол гэмтлийн үндэсний хөтөлбөр хариуцсан их эмч, статистик их, бага эмчийн бүрэлдэхүүнтэй осол гэмтлийн тандалт мэдээллийн багтай байна.
- 1.4 Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төв, сум дундын эмнэлгийн ерөнхий эмч, төвийн даргаар ахлуулсан сум, өрхийн их эмч, үндэсний хөтөлбөр хариуцсан сувилагч, бага эмч, статистик бага эмч зэрэг мэргэжилтнүүдийн бүрэлдэхүүнтэй баг ажиллана.
- 1.5 Төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төв, осол гэмтэл, мэс заслын чиглэлээр тусгай зөвшөөрөл авсан хувийн хэвшлийн болон бусад эмнэлгүүдийн тандалт, мэдээллийн багийн дарга нь тухайн эмнэлэг, төвийн дарга, захирал нар байх ба тархвар судлаач, чанарын менежер, амбулатори, яаралтай тусlamж-хүлээн авах тасгийн эрхлэгч, гэмтэл, согогийн их эмч, статистик их, бага эмч зэрэг мэргэжилтнүүдийн бүрэлдэхүүнтэй байна.

Хоёр. Мэдээлэл хүлээн авах, тайлагнах

- 2.1 “Осол гэмтлийн тандалт, мэдээллийн алба” /цаашид алба гэх/ нь аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газар, дүүргийн эрүүл мэндийн төв болон тусгай мэргэжлийн төвүүд, хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагуудаас осол гэмтлийн бүртгэгдсэн мэдээг сар бүрийн 5-ны дотор H-info 3.0 програмд шивж оруулан цахим хэлбэрээр хүлээж авна.
- 2.2 Алба нь Гэмтэл согог судлалын үндэсний төвийн хүлээн авах, яаралтай тусlamжийн тасагт бүртгэгдсэн тохиолдол бүрийг өдөр бүр авч, мэдээллийн санд оруулна.
- 2.3 Алба нь ирсэн мэдээг нэгтгэн, боловсруулалт, дүн шинжилгээ хийж, Эрүүл мэндийн хөгжлийн төв, Эрүүл мэндийн яаманд хэвлэмэл болон цахим хэлбэрээр сар бүрийн 15-ны дотор мэдээлнэ.
- 2.4 Осол гэмтлийн тохиолдлын мэдээний сангийн жилийн нэгдсэн тайланг Эрүүл мэндийн хөгжлийн төвд жил бүрийн 2-р сарын 15-ны дотор цахим болон цаасан хэлбэрээр хүргүүлнэ.
- 2.5 Алба нь нийтийг хамарсан осол гэмтэл болон онцгой тохиолдлуудыг 24 цагийн дотор Эрүүл мэндийн яамны Шуурхай удирдлагын төвд утсаар мэдээлнэ.

Гурав. Албаны үүрэг

3.1. Албаны даргын үүрэг

- 3.1.1. Албаны болон тандалтын нэгжүүдийн үйл ажиллагааг үнэлнэ.
- 3.1.2. Албаны үйл ажиллагааны төлөвлөгөөг батлуулж хэрэгжилтийг хангана.
- 3.1.3. Осол гэмтлийн мэдээний сангийн баяжуулалтанд хяналт тавина.
- 3.1.4. Осол гэмтлийн өвчлөл, нас баралтын тандалтын тогтолцоо /цаашид тандалтын тогтолцоо/ үйл ажиллагаанд явцын хяналт тогтмол хийж, тулгамдсан асуудлыг шийдвэрлэнэ.
- 3.1.5. Урьдчилан сэргийлүүлэх арга хэмжээг удирдан зохион байгуулна.
- 3.1.6. Осол гэмтлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд салбар хоорондын уялдааг зохицуулна.

3.2. Мэдээлэл зүйн мэргэжилтэн -статистикч их эмчийн гүйцэтгэх үүрэг

- 3.2.1. Осол гэмтлийн тандалтын нэгжүүдийн мэдээ ирүүлэлтэд хяналт тавьж, шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлнэ.

- 3.2.2. Осол гэмтлийн тохиолдлын цахим санг нэгтгэн, үндэсний хэмжээний осол гэмтлийн тандалтын мэдээний цахим болон цаасан сан үүсгэнэ.
- 3.2.3. Тандалтын тайланд дүгнэлт хийж, холбогдох эрүүл мэндийн болон бусад байгууллагуудад эргэн мэдээлэл хийнэ.

3.3. Тархвар судлаач эмчийн гүйцэтгэх үүрэг

- 3.3.1. Тандалтын үйл ажиллагааны журманд заагдсан болон цаг үеийн шаардлага бүхий осол гэмтлийн өвчлөл, нас баралтын тархвар зүйн судалгаа хийж, дүгнэлт гарган, асуудлыг холбогдох байгууллагатай хамтран шийдвэрлэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээ авна.
- 3.3.2. Тархвар судлаач эмч нь тандалтын мэдээнд тогтмол хяналт, үнэлгээ хийж, эргэн мэдээллээр хангана.

3.4. Нийгмийн эрүүл мэндийн мэргэжилтний үүрэг

- 3.4.1. Осол гэмтлээс урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээний талаар дүгнэлт, зөвлөмж, удирдамж, гарын авлага боловсруулан гаргана.
- 3.4.2. Осол гэмтэлтэй холбоотой мэдээллийг төрийн болон төрийн бус байгууллага, агентлаг, олон улсын байгууллагад мэдээлнэ.
- 3.4.3. Осол гэмтлийн өвчлөл болон урьдчилан сэргийлэлттэй холбоотой мэдээллийг сонин хэвлэл, олон нийтийн мэдээллийн хэрэгслээр мэдээлнэ.
- 3.4.4. Осол гэмтлийн тандалтын мэргэжилтнүүдийн сургалтын төлөвлөгөө боловсруулан хэрэгжилтийг хангана.

3.5. Статистикч бага эмчийн гүйцэтгэх үүрэг

- 3.5.1. “Осол гэмтлийн тохиолдлыг бүртгэх маягт, бусад бичиг баримтуудын хөтлөлтөд хяналт тавьж, гарсан алдааг маягтыг хөтөлсөн эмч, мэргэжилтнээр засуулах арга хэмжээ авна.
- 3.5.2. Осол гэмтлийн тандалтын мэдээг нэгтгэн, тандалтын нэгжийн дарга, статистикч их эмч, тархвар судлаач эмч, НЭМ-ийн мэргэжилтэнд мэдээлнэ.
- 3.5.3. Осол гэмтлийн тохиолдлын сангаас шаардлагатай мэдээлэл, судалгааны тоо баримтыг түүвэрлэн бэлтгэнэ.

3.6. Мэдээллийн технологийн үүрэг

- 3.6.1. Тандалтын тогтолцоонд ашиглаж буй программ хангамжийн хэвийн үйл ажиллагааг хангана.
- 3.6.2. Албаны компьютер болон бусад техник дагалдах хэрэгслийн хэвийн үйл ажиллагааг хангана.
- 3.6.3. Тандалт мэдээллийн албаны дотоод сүлжээ, интернетийн тогтвортой болон аюулгүй ажиллагааг хангаж ажиллана.
- 3.6.4. Тандалт мэдээллийн албаны цахим хуудасны хэвийн үйл ажиллагааг тогтвортой хангана, үйлчлүүлэгчдэд болон иргэдэд зориулсан зөвлөгөө мэдээ мэдээллийг тогтмол цахим хуудсанд байршуулна.